МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Сүхбаатарын ЭРДЭНЭБАТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-29-74, Факс: 32-70-16
E-mail: erdenebat@parliament.mn
http://www.parliament.mn

2025.11.24 № УИХ-03/13361

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА О.НОМИНЧИМЭГ ТАНАА

Хүсэлт уламжлах тухай

Монгол Улсын Их хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд тэтгэврийн зээлийн асуудлаар Монголбанкинд асуулт тавьсан бөгөөд хариуг 2025 оны 11 сарын 11-ний өдрийн А-1/867 албан тоотоор ирүүлсэн болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд асуултын хариуг Өргөдлийн байнгын хорооны хурлаар нэгтгэн хэлэлцүүлж өгнө үү.

Монголбанкинд хүргүүлсэн асуулт болон ирүүлсэн хариуг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт .1.. хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.ЭРДЭНЭБАТ

2025051

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.10.27 № 47

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООН
ДАРГА Б.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

Тэтгэврийн зээлийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд ахмадуудын зүгээс ирүүлсэн санал, хүсэлтийг үндэслэн мөн арилжааны банкууд тэтгэврийн зээлийн хүүг нэмэгдүүлж, зээл олгох хугацааг 6, 12, 18 сарын хугацаатайгаар хязгаарлалт тогтоон олгож байгаа нь ахмад настнуудад хүндрэл үүсгэж байгаатай холбогдуулан дараах асуултыг тавьж байна.

1.Тэтгэврийн зээлийн хүүг нэмсэн үндэслэл, шалтгаан;

2.Тэтгэврийн зээлийн хугацааг хязгаарлах шийдвэрийг анх гаргасан шалтгаан, үндэслэл, 36 сараар олгох боломжийн талаар;

3.Монголбанкнаас тэтгэврийн зээлийн эрсдэлээр жигнэсэн активын хувь хэмжээг 150 хувь буюу хамгийн өндөр эрсдэлтэй гэж тооцох болсон шалтгаан, үндэслэл, ердийн зээлтэй адилтган тооцох эсхүл бууруулах боломжийн талаар;

4.Арилжааны банкуудад зээл олгоход шаардагдах эх үүсвэрийг хүүгүй, эсвэл бага хүүтэй олгох, мөн заавал байлгах нөөцийн тооцооллоос хасах замаар зээлийн хүүг бууруулах, хугацааг нэмэх боломжтой эсэх талаар;

5.Ахмадуудад олгох бусад зээлийн бүтээгдэхүүнийг (орон сууцны, төслийн, эмчилгээ, сувилгаа, эрүүл мэндийн үйлчилгээний зориулалттай зээл, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих гэх мэт) бий болгох талаар ямар арга хэмжээ авч байгаа талаар.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ӨРДЭНЭБАТ

2025000075

МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК
Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2025.11.11 № А-1/867

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.ЭРДЭНЭБАТ ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

Таны 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 47 дугаартай албан бичгээр тэтгэврийн зээлд тавьсан хугацааны хязгаарлалт, хүү нэмэгдсэн шалтгаан зэрэг асуудлаар тавьсан асуултад дараах тайлбарыг хүргэж байна.

1 ба 2. Тэтгэврийн зээлийн хүү, нөхцөлийн тухай:

Монголбанк нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргийн хүрээнд тодорхой чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд банкны үйл ажиллагаа, дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хуулиар хориглосон байдаг. Тодруулбал, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дах хэсэгт "Монголбанк хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа банкны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй" гэж, Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт "Банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцөлийн дагуу зээл олгож болох бөгөөд зээлийн хүүг өөрөө тогтооно", тус хуулийн 10.3 дах хэсэгт "Банкны зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна" гэж, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай (БЭБХЭМХМХШЗҮАТ) хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дах хэсэгт "Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, зээлийн хүү, хугацаа болон бусад нөхцөлийн талаар зээлдэгчтэй харилцан тохиролцож байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр түүнд зээлийн данс нээж, зээл олгоно." гэж тус тус заасан байдаг.

Иймд Монголбанкаас банкны зээлийн хүү, нөхцөлийг тогтооход хөндлөнгөөс оролцох боломжгүй буюу хуулиар тусгайлан зохицуулагдсан харилцаа байх бөгөөд банк нь өөрийн зээлийн бүтээгдэхүүний хүү, нөхцөлийг тогтоох эрхтэй байна. Харин БЭБХЭМХМХШЗҮАТ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дах хэсэгт "Зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина" гэж заасны дагуу Монголбанк нь зөвхөн банкны зээлийн хүүг бодох, тооцох аргачлалыг баталж, түүнд хяналт тавин ажиллаж байгаа болно. Дээр дурдсанчлан зээлийн нөхцөл нь зээлдүүлэгчийн өөрийн эрхийн хүрээнд тогтоож байгаа тул тэтгэврийн зээлийн хугацааны талаар мөн Монголбанкнаас ямар нэгэн хязгаарлалт хийгээгүй болно.

1525023337

Харин Монголбанкнаас Монгол Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр батлсан “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” 79 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд эрсдэл багатай зээлдэгчид олгох зээлийн хүүг прайм хүү (прайм хүү гэж суурь хүүнд үйл ажиллагааны зардал, татварын зардал, зорилтот ашиг, зээлийн эрсдэл болон заавал байлгах нөөцийн алдагдсан боломжийн зардлыг шингээж тооцсон зээлийн хамгийн бага хүүг хэлнэ)-д үндэслэн тогтоох, зээлдэгчид олгох зээлийн хүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй зарладаг болох боломжийн талаар эхний байдлаар судлан ажиллаж байна.

3 ба 4. Тэтгэврийн зээлд авч хэрэгжүүлж байгаа зохицуулалтын тухай:

Монголбанк нь дээр дурдсан макро зохистой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх хүрээнд тэтгэврийн зээлийн хэт өсөлтийг сааруулах, зээлдэгчийн зээлийн өрийн дарамтыг бууруулах, ахмад настны амьжиргааг хамгаалах мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 02/693 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг харгалзан Монголбанкнаас 2023 оны 12 дугаар сараас эхлэн тодорхой нөхцөлийг (6 сараас дээш хугацаатай олгосон эсхүл зээлийн сарын төлбөрөө төлсний дараах үлдэгдэл тэтгэврийн орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага байх) хангасан тэтгэврийн зээлд 150 хувийн эрсдэлийн жинг тогтоон мөрдүүлж байна. Мөн тус хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “1/банкны заавал байлгах нөөц, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох” гэж заасны дагуу Монголбанк нь мөнгөний болон макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх, бодлогын зорилтуудыг хангах хүрээнд банкны заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг тогтоон мөрдүүлж байна. Энэхүү шийдвэрийг Мөнгөний бодлогын хороо (Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, хараат бус 4 гишүүний бүрэлдэхүүнтэй) нь илүү өргөн агуулгаар макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг харгалзан үзэж хараат бусаар шийдвэрлэдэг. Тэтгэврийн зээлтэй холбоотой гарсан өмнөх шийдвэрийг нэр бүхий улс төрчид хөндлөнгөөс оролцож цуцлуулсан явдал нь Төв банкны хараат бус байдалд улс төрөөс халдаж, шийдвэрийг цуцлуулсан анхны тохиолдол болсон тэдийгүй тухайн нөхцөл байдлыг дордуулсан харамсалтай явдал болсон юм. Таны асуулгад дурдсан эрсдэлийн жин зээлийн хүүд том нөлөөгүй юм. Тухайлбал, эрсдэлийн жинг 50 нэгж хувиар бууруулахад дунджаар сарын хүү 0.04%-иар (сарын хүү 1.5%-иас 1.46% болох) буюу жилийн дүнгээр 0.5%-иар (жилийн хүү 18%-иас 17.5% болох) бага байх тооцоолол гарч байна.

4. Банканд хөнгөлөлттэй нөхцөлөөр эх үүсвэр олгох талаар:

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 7 дахь заалтын дагуу Монголбанк нь төсвийн шинжтэй үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Мөн тус хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын дагуу Монголбанк нь хүүгийн нэгдсэн бодлого явуулах зохицуулалттай. Эдгээр зохицуулалтын хүрээнд Монголбанкны бодлогын хүү 12%, репо санхүүжилтийн хүү 12%-13% байна. Өөрөөр хэлбэл арилжааны банкуудад тэтгэврийн зээл олгоход шаардагдах тодорхой эх үүсвэрийг тусгайлан бага хүүтэйгээр эсвэл хүүгүй олгох боломжгүй юм.

5. Ахмадуудад олгох боломжтой бусад зээлийн бүтээгдэхүүний талаар:

Тэтгэврийн орлоготой иргэд хэрэглээний бус буюу бизнесийн зээл, жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийг тухайн бизнесийн үйл ажиллагаанаас олох ирээдүйн орлогыг барьцаалж авах боломжтой байна. Өөрөөр хэлбэл, өндөр настай иргэн нь жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхэлдэг тохиолдолд тухайн бизнесийн үйл ажиллагаанд тулгуурлан банкны зээл авах боломж нь нээлттэй байна. Банкуудын бичил бизнесийн зээлийн ерөнхий нөхцөлийг авч үзвэл жилийн хүү 19.2%-24%, харин хугацааны хувьд 40 хүртэл сар, зээлийн дээд хэмжээ нь 50 сая төгрөг хүртэл буюу илүү уян хатан байгааг үүгээр уламжилъя.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.10.27 № 47

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООН
ДАРГА Б.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

Тэтгэврийн зээлийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд ахмадуудын зүгээс ирүүлсэн санал, хүсэлтийг үндэслэн мөн арилжааны банкууд тэтгэврийн зээлийн хүүг нэмэгдүүлж, зээл олгох хугацааг 6, 12, 18 сарын хугацаатайгаар хязгаарлалт тогтоон олгож байгаа нь ахмад настнуудад хүндрэл үүсгэж байгаатай холбогдуулан дараах асуултыг тавьж байна.

1.Тэтгэврийн зээлийн хүүг нэмсэн үндэслэл, шалтгаан;

2.Тэтгэврийн зээлийн хугацааг хязгаарлах шийдвэрийг анх гаргасан шалтгаан, үндэслэл, 36 сараар олгох боломжийн талаар;

3.Монголбанкнаас тэтгэврийн зээлийн эрсдэлээр жигнэсэн активын хувь хэмжээг 150 хувь буюу хамгийн өндөр эрсдэлтэй гэж тооцох болсон шалтгаан, үндэслэл, ердийн зээлтэй адилтган тооцох эсхүл бууруулах боломжийн талаар;

4.Арилжааны банкуудад зээл олгоход шаардагдах эх үүсвэрийг хүүгүй, эсвэл бага хүүтэй олгох, мөн заавал байлгах нөөцийн тооцоллоос хасах замаар зээлийн хүүг бууруулах, хугацааг нэмэх боломжтой эсэх талаар;

5.Ахмадуудад олгох бусад зээлийн бүтээгдэхүүнийг (орон сууцны, төслийн, эмчилгээ, сувилгаа, эрүүл мэндийн үйлчилгээний зориулалттай зээл, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих гэх мэт) бий болгох талаар ямар арга хэмжээ авч байгаа талаар.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ӨРДЭНЭБАТ

2025000075

МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК
Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2025.11.11 № А-1/867
танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.ЭРДЭНЭБАТ ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

Таны 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 47 дугаартай албан бичгээр тэтгэврийн зээлд тавьсан хугацааны хязгаарлалт, хүү нэмэгдсэн шалтгаан зэрэг асуудлаар тавьсан асуултад дараах тайлбарыг хүргэж байна.

1 ба 2. Тэтгэврийн зээлийн хүү, нөхцөлийн тухай:

Монголбанк нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргийн хүрээнд тодорхой чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд банкны үйл ажиллагаа, дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хуулиар хориглосон байдаг. Тодруулбал, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дах хэсэгт "Монголбанк хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа банкны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй" гэж, Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт "Банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцөлийн дагуу зээл олгож болох бөгөөд зээлийн хүүг өөрөө тогтооно", тус хуулийн 10.3 дах хэсэгт "Банкны зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна" гэж, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай (БЭБХЭМХМХШЗҮАТ) хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дах хэсэгт "Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, зээлийн хүү, хугацаа болон бусад нөхцөлийн талаар зээлдэгчтэй харилцан тохиролцож байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр түүнд зээлийн данс нээж, зээл олгоно." гэж тус тус заасан байдаг.

Иймд Монголбанкаас банкны зээлийн хүү, нөхцөлийг тогтооход хөндлөнгөөс оролцох боломжгүй буюу хуулиар тусгайлан зохицуулагдсан харилцаа байх бөгөөд банк нь өөрийн зээлийн бүтээгдэхүүний хүү, нөхцөлийг тогтоох эрхтэй байна. Харин БЭБХЭМХМХШЗҮАТ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дах хэсэгт "Зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина" гэж заасны дагуу Монголбанк нь зөвхөн банкны зээлийн хүүг бодох, тооцох аргачлалыг баталж, түүнд хяналт тавин ажиллаж байгаа болно. Дээр дурдсанчлан зээлийн нөхцөл нь зээлдүүлэгчийн өөрийн эрхийн хүрээнд тогтоож байгаа тул тэтгэврийн зээлийн хугацааны талаар мөн Монголбанкнаас ямар нэгэн хязгаарлалт хийгээгүй болно.

1525023337

Харин Монголбанкнаас Монгол Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр баталсан “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” 79 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд эрсдэл багатай зээлдэгчид олгох зээлийн хүүг прайм хүү (прайм хүү гэж суурь хүүнд үйл ажиллагааны зардал, татварын зардал, зорилтот ашиг, зээлийн эрсдэл болон заавал байлгах нөөцийн алдагдсан боломжийн зардлыг шингээж тооцсон зээлийн хамгийн бага хүүг хэлнэ)-д үндэслэн тогтоох, зээлдэгчид олгох зээлийн хүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй зарладаг болох боломжийн талаар эхний байдлаар судлан ажиллаж байна.

3 ба 4. Тэтгэврийн зээлд авч хэрэгжүүлж байгаа зохицуулалтын тухай:

Монголбанк нь дээр дурдсан макро зохистой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх хүрээнд тэтгэврийн зээлийн хэт өсөлтийг сааруулах, зээлдэгчийн зээлийн өрийн дарамтыг бууруулах, ахмад настны амьжиргааг хамгаалах мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 02/693 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг харгалзан Монголбанкнаас 2023 оны 12 дугаар сараас эхлэн тодорхой нөхцөлийг (6 сараас дээш хугацаатай олгосон эсхүл зээлийн сарын төлбөрөө төлсний дараах үлдэгдэл тэтгэврийн орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага байх) хангасан тэтгэврийн зээлд 150 хувийн эрсдэлийн жинг тогтоон мөрдүүлж байна. Мөн тус хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “1/банкны заавал байлгах нөөц, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох” гэж заасны дагуу Монголбанк нь мөнгөний болон макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх, бодлогын зорилтуудыг хангах хүрээнд банкны заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг тогтоон мөрдүүлж байна. Энэхүү шийдвэрийг Мөнгөний бодлогын хороо (Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, хараат бус 4 гишүүний бүрэлдэхүүнтэй) нь илүү өргөн агуулгаар макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг харгалзан үзэж хараат бусаар шийдвэрлэдэг. Тэтгэврийн зээлтэй холбоотой гарсан өмнөх шийдвэрийг нэр бүхий улс төрчид хөндлөнгөөс оролцож цуцлуулсан явдал нь Төв банкны хараат бус байдалд улс төрөөс халдаж, шийдвэрийг цуцлуулсан анхны тохиолдол болсон төдийгүй тухайн нөхцөл байдлыг дордуулсан харамсалтай явдал болсон юм. Таны асуулгад дурдсан эрсдэлийн жин зээлийн хүүд том нөлөөгүй юм. Тухайлбал, эрсдэлийн жинг 50 нэгж хувиар бууруулахад дунджаар сарын хүү 0.04%-иар (сарын хүү 1.5%-иас 1.46% болох) буюу жилийн дүнгээр 0.5%-иар (жилийн хүү 18%-иас 17.5% болох) бага байх тооцоолол гарч байна.

4. Банканд хөнгөлөлттэй нөхцөлөөр эх үүсвэр олгох талаар:

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 7 дахь заалтын дагуу Монголбанк нь төсвийн шинжтэй үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Мөн тус хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын дагуу Монголбанк нь хүүгийн нэгдсэн бодлого явуулах зохицуулалттай. Эдгээр зохицуулалтын хүрээнд Монголбанкны бодлогын хүү 12%, репо санхүүжилтийн хүү 12%-13% байна. Өөрөөр хэлбэл арилжааны банкуудад тэтгэврийн зээл олгоход шаардагдах тодорхой эх үүсвэрийг тусгайлан бага хүүтэйгээр эсвэл хүүгүй олгох боломжгүй юм.

5. Ахмадуудад олгох боломжтой бусад зээлийн бүтээгдэхүүний талаар:

Тэтгэврийн орлоготой иргэд хэрэглээний бус буюу бизнесийн зээл, жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийг тухайн бизнесийн үйл ажиллагаанаас олох ирээдүйн орлогыг барьцаалж авах боломжтой байна. Өөрөөр хэлбэл, өндөр настай иргэн нь жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхэлдэг тохиолдолд тухайн бизнесийн үйл ажиллагаанд тулгуурлан банкны зээл авах боломж нь нээлттэй байна. Банкуудын бичил бизнесийн зээлийн ерөнхий нөхцөлийг авч үзвэл жилийн хүү 19.2%-24%, харин хугацааны хувьд 40 хүртэл сар, зээлийн дээд хэмжээ нь 50 сая төгрөг хүртэл буюу илүү уян хатан байгааг үүгээр уламжилъя.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН